



БАТЛАВ. МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. АНХБААТАР



**БИЧГИЙН ЦААС /A4, A3/ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Бичгийн цаас /A4, A3/ нийлүүлэх гүйцэтгэгчийг
харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах

Төслийн дугаар: МШ/202001100

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Монгол шуудан” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос бичгийн цаас /A4, A3/ нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020.04.02-ны өдрийн 10 цагаас өмнө tender.gov.mn /хялбаршуулсан цахим хэлбэрээр/ хаягаар ирүүлнэ.
Утас: 70078971)

Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Хуудас бүрийг нэг файл болгохгүй агуулга тус бүрээр нь (pdf)-файл үүсгэн цахим системд илгээх шаардлагатай.

*Монгол шуудан ХК, Чингэлтэй, 1-р хороо,
Төв шуудан, Баруун хаалга, 2 давхар, 209 тоот
Утас: 70078971*

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p> <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> <p>3. Тендерийн иж бүрдэл</p> <p>4. Тогтмол үнэ</p> <p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p> <p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> <p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p> <p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(в) Компанийн гэрчилгээний хуулбар;</p> <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p> <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |
|---|---|

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫ-ХОЛБОГОХ ЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------------|---|
| ТОӨЗ 1.1 | <p>Сүүлийн 1 жилийн /2019 он/ санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн эх хувийн хамт ирүүлэх, хуулбар хувь бол нотариатаар баталгаажуулан ирүүлнэ/; Шаардлагатай</p> <p>Ашигтай ажилласан жил: 2019 он /шаардлагатай/</p> <p>Сүүлийн 1 жилийн /2019 он/ туршлагын мэдээлэл /ижил төстэй ажлын гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний эх хувийг ирүүлэх, хуулбар хувь бол нотариатаар баталгаажуулан ирүүлнэ/; Шаардлагатай</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Шаардлагагүй</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Хуудас бүрийг нэг файл болгохгүй агуулга тус бүрээр нь (pdf)-файл үүсгэн цахим системд илгээх шаардлагатай.</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТОӨЗ 2.2 | <p>Байгууллагын хаяг: Монгол шуудан ХК, Чингэлтэй, 1-р хороо, Төв шуудан, Баруун хаалга,</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 даевхар, 209 тоот, Утас: 70078971</p> |

Техникийн тодорхойлолт

/Бичгийн цаас А4, А3/

2020 онд хангах А4 болон А3 төрлийн бичгийн цаасны шаардлага үзүүлэлт болон тоо хэмжээг доор үзүүлэв

| № | Нэр, төрөл | Нягтрал, жин | Тоо, хэмжээ |
|----------|-------------------|---------------------|--------------------|
| 1 | А4 бичгийн цаас | 80 гр | 2200 боодол |
| 2 | А3 бичгийн цаас | 80 гр | 130 боодол |

Дараах шаардлагыг хангасан байх:

1. Албан ёсны дистрибутерийн /гэрээт борлуулагч/ эрхтэйгээр борлуулдаг байх
2. Бичгийн цаасны олон улсын стандартыг хангасан байх
3. Цаасны нягтрал 80гр байх
4. Чанарын хувьд Double A тэй дүйцэхүйц бичгийн цаас байх
5. Хүргэлтийн нийлүүлэгч компани өөрөө хариуцах ба тухайн хэрэгцээт захиалгыг өгсөн өдрөөс хойш 2 хоногийн дотор нийлүүлэх,
6. 2 талаараа хэвлэдэг,
7. Лазер болон шингэн хортой принтерт хэрэглэдэг,
8. Цахилгаанждаггүй /давхар гардаггүй/,
9. Шохойжилт багатай /эко/,
- 10.ISO 9001, 14001 стандартуудыш нотлох гэрчилгээ болон худалдах эрхийн зөвшөөрөлтэй байх,
- 11.Дээрх тоо хэмжээгээр Бичгийн цаасыг 1 жилийн хугацаанд нийлүүлнэ.

Бараа хүргэх газар: Монгол шуудан ХК, Чингэлтэй, 1-р хороо, Төв шуудан, Баруун хаалга,

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатар танаа

- Бид, [тэндерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[too]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал Үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тэндерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш хийнэ. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл байх ба НӨАТ орсон болно. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Нийлүүлэх барааг компаниас томилогдсон комисс шалгаж авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 4) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: 7.2. Гэрээний үнэ гэрээний хүчинтэй хугацаанд тохируулахгүй тогтмол байна. Гэрээний үнийн дүнг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна |

